## ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ АРХАНГАЙ АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | Зарцуулсан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | |
| **3.1 Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | |
| 3.1.1. | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах. | - | Угийн бичиг хөтлөлтийн хувь | | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох арга хэмжээний хүрээнд угийн бичгийг хөтлөх арга зүйг нэмэгдүүлэх сургалтыг 19 сум насанд хүрэгч 95 нь сурагч, оюутан залуус оролцсон байна. Угийн бичгийг хэрхэн хөтлөх талаар дадлага ажилтай арга зүйн сургалтыг 6 байгууллагын 115 албан хаагчдад зохион байгуулан зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан бөгөөд Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах "Хүүхэд-хайр-хүндлэл" уриан дор гэр бүлийн зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөний оролцогч 100 хүнд "Ургийн бичиг - Улсын үндэс", "Хамтдаа алхах амьдрал" хосын харилцаа сэдвээр мэдээлэл өгч ажилласан. Дээрх үйл ажиллагаанд нийт 9.5 сая төгрөг зарцуулсан байна. | Хэрэгжсэн |
| 3.1.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд | | | | | | |
| 3.1.2.1. | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийлэлийн шалтгаан, нөхцлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. | 22500 | 1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1<br>2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоох хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг бүрэн ханган ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд "Хүүхэд-хайр-хүндлэл" уриан дор зохион байгуулж 7 баг, 3 сумын 50 гэр бүлийн 100 иргэн оролцлоо. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр 19 сумын 7757 иргэдийг оролцуулан зохион байгуулж ажилласан. Мөн Эрсдэлгүй ирээдүйн төлөө хамтдаа-2025" архины хамааралтай гэр бүлтэй ажиллах урт хугацааны хөтөлбөрийг | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | боловсруулан архины хамааралтай 16 гэр бүлийн 25 иргэнийг сонгон авч, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Эрсдлийн судалгаан дээр үндэслэн шуурхай тусламжийн багцын үйлчилгээг нийт 379 гэр бүлд үзүүлсэн зэрэг нийт21 арга хэмжээнд 7757 насанд хүрэгч, 3381 хүүхэд хамрагдаж, 379 гэр бүлд дэмжлэг үзүүлж ажилласан байна. Үйл ажиллагааны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 35.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дээрх үйл ажиллагаанд 17.160.000 төгрөг зарцуулагдсан байна. | |
| 3.1.2.2 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өрөгжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох | Орон нутгийн төсвийн хөрөнгө өр | Сэтгэл зүйн тусламж,үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар сайжирна. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс "Бүтээлч тархи", "Мөрөөдлийн кактус" сэтгэл зүйн хүрээлэн зэрэг ТББ-уудтай хамтран 19 сум, Эрдэнэбулган сумын 7 багийн ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, Түр хамгаалах байрны үйчлүүлэгч болон эрсдэлт нөхцөлд амьдарч буй 264 хүүхэд, 112 насанд хүрэгчидэд ганцаарчилсан зөвлөгөө, 412 хүүхдийг бүлгийн зөвлөгөөнд хамруулж ажилласанаар анхаарч, хяналтад авах шаардлагатай хүүхэд-38, Сурах зан үйлийн бэрхшээл, оюуны хомсдолтой-13, Бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй 12, Гэр бүлийн харилцааны зөрчилтэй -21, бэлгийн хүчирхийлэлд өртсөн-1 хүүхдийг илрүүлж ажилласан.<br>Сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд эцэг эх, асран хамгаалагчийн хүүхэдтэй ажиллах арга зүйг сайжруулж, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийн талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлж, гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байлыг хангахад анхаарч ажилласан байна. Арга хэмжээнд нийт 20.697.000 төгрөг төсөвлөгдөн зарцуулагдсан байна. | Хэрэгжсэн |
| 3.1.2.3 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн | Орон нутгийн төсвийн | 1.Батлагдсан төсөв-100%<br>2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны | Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүсэлт тавьж Орон нутгийн төсвөөс Түр хамгаалах байрны 2 нийгмийн ажилтны цалин хөлс 60.2 сая | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулна. | хөрөнгө өр | | зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна. | төгрөгийг шийдвэрлүүлсэн. Түр хамгааллах байрны хүний нөөцийн асуудлыг шийдвэрлүүлсэнээр 2025 онд гэр бүлийн болон, бэлгийн хүчирхийллийн хохирогч нийт 57 үйлчлүүлэгч хүлээн авч хариу үйлчилгээ үзүүлэн эрсдлийг бууруулан аюулгүй байдлыг бүрэн хангаж, түр хамгаалах байрны цогц үйлчилгээг үзүүлж, 55 үйлчлүүлэгчийг гэрт нь эргэн нэгтгэж, 4 үйлчлүүгчийг “Өнөр” бүл асрамжийн газарт холбон зуучлан хүлээлгэж өгсөн. | Хэрэгжсэн |
| 3.1.2.4 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулна | 22500 | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд Эрдэнэбулган сумын 187 эцэг, эх асран хамгаалагчдад “Гэр бүлийн харилцаа” сэдвээр, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд 19 сумын 950 өсвөр насны охидод Цахим орчны аюулгүй байдлын талаар, сургалт хийж, Цахим орчинд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 20 удаагийн постер мэдээлэл бэлтгэн түгээж 6000 орчим хүнд хүрсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэргэдэх цагдан хорих байранд саатуулагдаж байгаа 58 иргэнд архины хор уршгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг 4 удаа зохион байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр 3 хүн архины хамаарлаас бүрэн гарч, тогтмол орлоготой болж хөдөлмөр эрхэлж байна. Гэр бүлийн хохирогч болсон түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 7 насанд хүрэгчийг ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулж, эрүүл мэнд, хууль эрх зүйн зөвлөгөө үйлчилгээнд холбон зуучилснаар тухайн гэр бүлийн нөхцөл байдал сайжирч хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл ирүүлээгүй үр дүнтэй байна. Нийт сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 391 хүнийг хамруулсан бөгөөд 3.100.000 төгрөгийг зарцуулсан | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3 Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйл, 20 дүгээр зүйлийн 20.1, 20.3, 20.7, 20.9, 20.10 дахь заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 3.1.3.1 | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | 1,684,8 63.6 | 1.Төлөвлөгөө баталсан эсэх<br>2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Тайлант хугацаанд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл хоёр удаа хуралдаж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг шинэчилэн баталлаа. Хүүхдийн төлөө зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 25 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилт нь 96 хувьтай биелэсэн байна. Мөн 14 байгууллагаас тайлан авч нэгтгэн, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулсан нь хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд бодит ахиц гаргасан.. | Хэрэгжсэн |
| 3.1.3.2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх; | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна. | Аймгийн хэмжээнд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан 27 нэр төрлийн урлаг, спортын арга хэмжээнд оролцсон 16000 гаруй хүүхдийг соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулах тохиолдолд хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын дэргэдэх дугуйлан секцийн багш ажилчдад мэдээлэл хүргэж ажиллалаа. Биеийн тамир, спортын газар, Хас тамир ширээний теннисний клубтай хамтран эрсдэлт нөхцөлд амьдарч буй, хөгжлийн бэрхшээлтэй, Түр хамгаалах байраар үйлчлүүлж буй 17 хүүхдийг даам, шатар, усан бассейн, ширээний теннисний дугуйланд хамруулж хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Дээрх үйл ажиллагаанд нийт 9.5 сая төгрөг зарцуулсан байна. | Хэрэгжсэн |
| 3.1.3.3 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах; | | Баталсан төсвийн хэмжээ | “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 оны 1 сарын 16-наас 2 сарын 27-ныг хүртэл Ихтамир, Төвшрүүлэх, Батцэнгэл, Эрдэнэбулган суманд бүсчилэн бага насны хүүхдийн хөгжил төлөвшил, эрүүл мэнд, асаргаа, халамж, хүүхэд хамгаалал, зохистой хоол тэжээл сэдвийн хүрээнд аймгийн 35 цэцэрлэгийн 326 | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжсэн байна. | багш сургагч багшаар бэлтгэгдэн 9700 эцэг эхчүүдэд 105 удаагийн сургалт зохион байгуулсан. 2-5 насны 2800 хүүхдийн бие бялдрын хөгжлийн түвшинг тогтоож, хуваарийн дагуу 35 цэцэрлэгийн багш, тогооч, нярав, багшийн туслах эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад нүд, шүд, зүрхний эрт илрүүлэг үзлэгийг Нэгдсэн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудтай хамтарч зохион байгуулах тухай, мөн “Хараа шалгах чадвар эзэмших” сургалтыг аймгийн 30 ЕБС-ийн нийт 38 сургуулийн эмч, багш, нийгмийн ажилтнууд 2025 оны 4 дүгээр сарын 28-29-ны хооронд сургалтанд хамруулсан 19 сумын өрхийн эрүүл мэндийн төв нь бага насны хүүхдийн өсөлт, хөгжлийг тогтмол хяналт хийж байна. | |
| 3.1.3.4 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах; | | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо<br>2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/ | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | ААНОАТ-ын тухай хуулийн 22.9 дэх заалтаар 7 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж 220 татвар төлөгч хамрагдлаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг 2025 оны 08 дугаар сараас хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн татварын тайлангийн хугацаа болоогүй тул зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхойлох боломжгүй байна. | Хэрэгжсэн |
| 3.1.3.5.<br><br>Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцоон ы байгуулл агуудыг | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах; | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | Хүүхдийн оролцооны байгууллагууд ын үйл ажиллагаа сайжирсан байна. | “Жилийн луужингаа тохируулъя” 24 хүүхэд “COOL Z” эвент арга хэмжээний хүрээнд 127 хүүхэд оролцсон, “Spooky adventure” event арга хэмжээнд 1,2,3,4,5 сургуулийн 142 хүүхэд,<br>Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт болсон 134 дүгээр бүлгийн удирдагч бэлтгэх анхан шатны үндэсний сургалтанд болон “Сургуулийн орчин дах аюулгүй байдал”, “Мэргэжлийн чиг баримжааг хэрхэн тодорхойлох вэ?”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг сургалт нөлөөлийн ажлуудыг зохион байгуулж Эрдэнэбулган сумын 1,2,3,4,5 дугаар сургууль, Ирээдүй суруууль, Булган МСҮТ-ийн | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах; | | | | | хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тус бүр бичиг хэргийн багц олгож ажлласан байна. Нийт 20 удаагийн арга хэмжээнд нийт 9.324.800 төгрөг зарцуулагдаж 4309 хүүхдэд хамрагдсан байна. | |
| 3.1.3.6. | “Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх. | | 1.Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр 2025 оны 3 дугаар сарын 17-оос эхлэн Эрдэнэбулган сумын 6 баг дээр “Хүүхэд хамгаалагч” сайн дурын ажилтан ажиллаж байна.<br>Сайн дурын ажилтнуудыг чадавхжуулах сургалтын 3 удаа зохион байгуулан. долоо хоног бүрийн даваа, баасан гаргуудад арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна.<br>Энэ хугацаанд “Хүүхэд хамгаалагч” сайн дурын ажилтан өөрсдийн давуу тал, мэргэжлийн онцлогтоо тулгуурлан эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүд болон өрхүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн 7 арга хэмжээг 6 багт зохион байгуулан 43 зөрчилтэй объект илрүүлэн үүнээс 16 объектыг холбогдох газарт нь хүргэн шийдвэрлүүлсэн байна. Мөн Эрдэнэбулган сумын 6 багийн 6000 гаруй айл өрхөөр хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнуудтай хамтран хүүхдийн нөхцөл байдлын судалгааг гарган эрсдэлийн үнэлгээ хийн ажилласан байна. Сайн дурын ажилтанг ажиллуулснаар эрсдэлт орчин нөхцөлд амьдарч буй хүүхэд рүү чиглэсэн хариу үйлчилгээний хүртээмж нэмэгдэж эрсдэлтэй орчин буурсан үр дүн гарч байна. нийт санхүүжилт 17 сая төгрөг. | Хэрэгжсэн |
| 3.1.3.7 | Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн | | | | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 19 сумын 5298 иргэн, 76 төрийн байгууллагад “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын танилцуулга, байгууллагын | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | явуулахад тусламж, дэмжлэг үзүүлнэ | | | | хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт болон сургалт зохион байгуулж, Бизнесийн салбар дахь хүүхэд хамгааллын асуудлаар 21 аж, ахуй нэгжид сургалт зохион байгуулан электрон тамхи худалдан борлуулахгүй байхад чиглэсэн уриалга хүргүүлж, үр дүнд хяналт тавин ажиллаж байна. Мөн хүүхдийн эрсдлийг бууруулах хүрээнд Архангай аймаг дах Сум дундын шүүхтэй хамтын ажиллагааны хүрээнд хэргийн оролцогчоос хүсэлт гаргасны дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоолгох тухай иргэний 5 хэрэгт шүүгчийн захирамжийн дагуу шинжээчээр ажиллалаа. Шинжээчээр ажиллах явцдаа нийт 9 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ, хүүхдийн эрсдлийн үнэлгээ, сэтгэл зүйн судлагаа авч хугацаанд дүгнэлтийг шүүхэд хүргүүлж ажилласан байна. НҮБ-ийн хүүхдийн сангийн санхүүжилтээр Эрдэнэбулган сумын 6 багт "Хүүхэд хамгаалагч" сайн дурын ажилтан ажиллуулаж байна. Сум, багийн хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, чиглэлийн мэргэжилтэн, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 12 удаагийн арга зүйн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 250 хүнийг оролцуулсан байна. | |
| 3.1.4 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.5, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 26 дугаар зүйлийн 26.5, 27 дугаар зүйлийн 27.7, 31 дүгээр зүйлийн 31.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2.7, 40.4, 40.6, 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | |
| 3.1.4.1 | "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх; | 450292.9 | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна. | Архангай аймгийн хэмжээнд нийт 128 эцэг эхийн зөвлөл ажиллаж, үүнээс 80 байгууллага нь хүүхэд хамгааллын бодлоготой байна. Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 74 байгууллагын 327 гишүүдийг хамруулан зохион байгууллаа.<br>Мөн хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 19 сумын 65 байгууллагын 435 албан хаагчтай биечлэн уулзсан байна нийт хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулах ажлыг 140 байгууллагын 6662 албан хаагч иргэд олон нийтэд сургалт, мэдээлэл өгсөн байна. | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажилласаны үр дүнд 18 байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой болж, 3 байгууллага хүүхдийн өрөө шинээр байгуулан 23 байгууллага хүүхдийн буланг тохижуулсан байна. Тус арга хэмжээний хүрээнд 2,175,900 төгрөг зарцуулсан байна. | |
| 3.1.4.2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх; | | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Нийт эйбл системийн Эрсдлийн программд 1162 хүүхэд бүртгэлтэй байгаа бөгөөд 2025 онд 262 хүүхдийн мэдээллийг шинээр бүртгэж, эрсдлийн түвшинг тодорхойлсон. Эрсдлийн программд бүртгэгдсэн нийт хүүхдээс хурдан морины уралдаанч 100 хүүхдэд поло цамц, тамирын өмдний хослолны дэмжлэг үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхдийг хөгжлийн үйлчилгээнд холбон зуучилж, 325 хүүхдэд шуурхай тусламжийн багц олгож, Дэмжигч гэр бүл/ментор фэмили/ хөтөлбөрт 23 хүүхдийг холбон зуучилж, Канвас арт-сургалтад 20 хүүхдийг, "Бүтээлч тархи" ТББ-тай хамтран ганцаарчилсан зөвлөгөөнд 264 хүүхдийг хамруулж, Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 54 хүүхдийн эрсдлийн түвшнийг тодорхойлон эрүүл мэнд, халамжийн үйлчилгээнд холбон зуучилж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хүргэж ажилласан. | Хэрэгжсэн |
| 3.1.4.3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх; | | 1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Архангай аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/12 дугаар захирамжаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг 14 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. Тайлант хугацаанд хороо 4 удаа хуралдаж, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хууль зүйн хорооны даргаас гишүүдэд үүрэг чиглэл өгч, 2024 оны тайлантай танилцлаа.<br>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос нийт 26 хүүхэд үйлчилгээ авч байна. Үүнээс:<br>- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт 7 хүүхдийг сайн дурын ажилтан бэлтгэх сертификаттай сургалтад хамруулан 2 төрлийн сайн дурын | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Мөн тэдгээр хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нартай хариуцлагын гэрээ байгуулан хагас жилийн байдлаар нийт 9 удаагийн сургалтыг зохион байгуулж, тайлан мэдээг тухай бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн ажиллаж байна. Албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нийт 7 арга хэмжээ зохион байгуулсан байна.<br>- Тайлант хугацаанд 15 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангаж ажиллан 7 удаагийн шүүх хуралдаанд оролцож, хүүхдийн эрх ашгийг хамгаалан ажиллалаа. Бэлгийн хүчирхийллийн хохирогч 4 хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, 4 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчлүүлэгч нийт 26 хүүхдийг сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилж, сэтгэл хөдлөлөө зөвөөр илэрхийлэх ач холбогдлыг ойлгож, шаардлагатай үед хэнд хэрхэн хандах тусламж авах талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн байна.<br>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусган 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлж ажилласан. нийт 7.5 сая төгрөг зарцуулсан байна. | |
| 3.1.4.4 | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих; | | 1.Хяналт, шалгалтын тоо,<br>2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | Монгол улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Аймгийн Засаг даргын 2025 оны 1 дүгээр сарын 21-ний А/23 захирамжаар Хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглох тухай захирамж гарган сумдын мэргэжилтнүүдэд 3 удаагийн сургалт, 2 удаагийн чиглэлийг хүргүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Аймгийн Засаг даргын 2025 оны а/139 дүгээр захирамжийн хүрээнд Өндөр-Улаан, Хотонт, Эрдэнэбулган сумуудад бүсийн уралдаан, Аймгийн баяр наадам, 100 жилийн ойтой 2 суманд | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уралдаанч хүүхдийн эрх аюулгүй байдлыг ханган ажилласан. Тус уралдаануудыг зохион байгуулахад Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгаалын газрын даргын 2025 оны 4 дүгээр сарын 18-ний 123 дугаар албан бичгээр чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласанаар аймаг, сум, бүсийн бүх уралдаануудад хүүхэд хамгааллын баг томилогдон уралдаанч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Үйл ажиллагааны үр дүнд бүс, аймаг, сумын хэмжээний 40 удаагийн уралдаанд 1757 уралдаанч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, хүүхдүүдийг бүртгэлийг системд цахимаар бүртгэж, гэнэтийн ослын даатгалд 100 хувь хамруууллаа. Дээрх үйл ажиллагаанд 11.600.000 төгрөг зарцуулаа. | |
| 3.1.4.5 | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх; | | 1.Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | Улаанбурхан өвчний тархалт дэгдэлт гарсантай холбогдуулан Түр хамгаалах байр, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 369 сурагчдаас тандалт судалгаа авч хариу үйлчилгээнд холбон зуучиллаа. Хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээний маягтыг эрсдэлд орсон айл өрхүүдээс хэрхэн авах талаарх сургалт мэдээллийг аймгийн ОБГ-тай хамтран 19 сумдад хүргэн “Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг боловсруулж, хүүхдийн аюулгүй байдал, ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны үнэлгээ хийгдэх ажлыг Аймгийн Онцгой байдлын газар, ЭБЦТС ТӨХК, газруудтай хамтран зохион байгуулж нийт 448 айл өрхөөр явж эцэг эх, асран хамгаалагч нарт мэдлэг, мэдээлэл хүргэсэн. Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”, “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага” MNS6948:2021 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд гамшгийн үед хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх сургалтыг 14 сумын 150 хүүхдэд зохион байгууллаа.. Нийт | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарцуулагдсан төсөв 4.869.000 төгрөг. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийн 97% -тай хэрэгжсэн байна. | |
| 3.1.4.6 | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх; | | Осол гэмтлийн буурсан хувь | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Архангай сайхан бүсгүйчүүд групптэй хамтран "Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье" сарын аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хуулийн талаар олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх 4 постер, 1 видео контентийг нийтэлсэн байна. Хүүхдийн тоглоомын талбай-5, олон нийтийн газрууд, гудамж талбай-10 газрыг эмэгтэйчүүдийн оролцоотойгоор цэвэрлэж, аюулгүй байдлыг хангах тулд шаардлагатай засвар үйлчилгээг хийлээ. Сум багийн Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтнууд 6 багийн хүүхэд хамгаалагч нартай хамтран 6000 гаруй айл өрхөөр явж амьдарч буй орчны галын болон цахилгааны аюулгүй байдалд үнэлгээ хийн гуу жалга, цас хунгарласан газруудад хүүхдийг тоглуулахгүй сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хүргэн хүүхдийн нөхцөл байдлын судалгаа, эрсдлийн үнэлгээ хийн ажилласан байна. Сайн дурын ажилтанг ажиллуулсанаар эрсдэлт орчин нөхцөлд амьдарч буй хүүхэд рүү чиглэсэн хариу үйлчилгээний хүртээмж нэмэгдэж эрсдэлтэй орчин буурсан үр дүн гарч байна. Мөн аймгийн Прокурорын газартай хамтран Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн-1, цэцэрлэг сургуулийн дэргэдэх 12 тоглоомын талбайд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 6 төрлийн зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгуулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажилласан. | Хэрэгжсэн |
| 3.1.4.7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн | Аймгийн Прокурорын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, ХХААГ-тай хамтран Булган сумын дотуур байр, Эрдэнэбулган сумын 1-5 дугаар сургууль, Ирээдүй сургууль цэцэрлэгийн цогцолбор, Биллиард, авто угаалга, барилга байгууламж зэрэг нийт 12 байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ХГБХХ газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөр, шалгах хуудсын дагуу 4 | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах. | | | зөрчлийг бууруулсан байна. | удаагийн хяналт, шалгалтын ажлыг зохион байгууллаа. Хяналт шалгалтын хүрээнд хүүхдийн эрхийн 17 зөрчил, дутагдал илэрч,зөрчлийг арилгах чиглэлээр 5 албан шаардлага, 6 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хүүхдийн эрхийг зөрчсөн 3 багшид зөрчлийн хэрэг нээн, холбогдогчид хариуцлага тооцон ажилласан. Аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран "Хамтдаа сэргийлье, шалгая, хамгаалъя" аяныг 16 хоногийн хугацаанд зохион байгуулж, өдөр өнжүүлэх төв, сүм хийд, хүүхэд харах үйлчилгээ, худалдаа үйлчилгээний газар, PC тоглоомын газар зэрэг 23 обьектэд хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 4 зөрчил дутагдлыг илрүүлэн, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 оны 19 тоот зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | |
| **3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;** | | | | | | |
| 3.2.1 | Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 33 дугаар зүйлийн 33.1, 36 дугаар зүйлийн 36.1.3, 159 дүгээр зүйлийн 159.2 заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | |
| 3.2.1.1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | 2074121.9 | Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээний ажлууд тусгагдсаны дагуу 22 аж ахуйн нэгж байгууллагын 83 албан хаагчдад 4 удаагийн сургалт зохион байгуулж мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. | Хэрэгжсэн |
| 3.2.1.2 | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгуулагын тоо<br>2.Зохион байгуулсан сургалтын тоо | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн | 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ХХҮЕГ-ын даргын 01/904 тоот хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдамжийн дагуу 35 ААНБ-д хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээг авах саналыг хүргүүлсэн.<br>Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй 2 ААНБ-д 3, | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | | даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | 4 улиралд хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээг хөдөлмөрийн харилцааны мэргэшсэн зөвлөхтэй хамтран 74 ажилтан, албан хаагчдад зохион байгууллаа.<br>Орон нутгийн Тамир телевиз-тэй хамтран хөдөлмөрийн харилцааны талаарх ойлголт мэдээллийг иргэд ААН, байгууллагад олон нийтийн сүлжээ ашиглан сурталчлах ажлыг зохион байгуулж, Эрдэнэбулган сумын 28 аж ахуй нэгж байгууллагын нийт 60 ажил олгогч эзэд, ажилтан албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгууллаа. | |
| 3.2.1.3 | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Эрдэнэбулган сумын Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороонд гаргасан 7 иргэний гомдлыг бүртгэн авч, 6 иргэний гомдлыг хөдөлмөрийн тухай хуулийн 154.3-т заасан хуулийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэж Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хороонд тайлагнасан. Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хорооны хуралд нэр иргэн өөрөө ирээгүй шалтгаанаар тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. | Хэрэгжсэн |
| 3.2.1.4 | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах. | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооноос аймгийн гурван талт хамтын хэлэлцээрийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 1 хамтын хэлэлцээрийг хянан бүртгэсэн.<br>Тус хэлэлцээрийг аймгийн засаг дарга, үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогч эздийн холбоо хамтран 3 жилийн хугацаатай байгуулж хүчин төгөлдөр хэвээр мөрдөн ажиллаж байна. | Хэрэгжсэн |
| 3.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 3.2.2.1 | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг | 266434 3.3 | 1. Бодлогын баримт бичгийн тоо, 2. Судалгаа, мэдээллийн тоо | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг | Архангай аймгийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, чиг хандлагад үндэслэн 19 суманд үйлчилгээ эрхлэж буй 106 иргэнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцэх 8 чиглэлийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, 84 ажил олгогчоос судалгаа авч, санал | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | | боловсруулсан байна. | боловсруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.<br><br>2025 онд орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 28 аж ахуй нэгжээс судалгаа авсан. Орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээ эрхэлж буй “Нутаг хүнс” ХХК, “Ашид бэхи” ХХК, Тэргүүн-Ар ХХК-аас ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч 17 иргэний ажилд зуучилсан. Нутаг хүнс ХХК-ийн охин компани болох Локал рүүтс зуу ХХК нь ажил идэвхитэй хайж байгаа 5 иргэнийг, Тэргүүн Ар ХХК нь хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, ажил олгогчийг дэмжих урамшуулалд хамрагдахаар гэрээ байгуулан ажилласан. | |
| 3.2.2.2 | Орон нутгийн ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын статистик мэдээлэл, бүртгэлтэй ажилгүй, ажлын байрны захиалга зэрэг захиргааны мэдээний чанарыг сайжруулах, тогтмол шинэчлэх | | Судалгаа, мэдээллийн тоо | Аймгийн/сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем e-job платформд модуль тус бүрээр цаг тухай бүр бүртгэл хийж, мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.<br>- Ажлын байрны захиалга 1682<br>- Ажилд зуучлал 904<br>- Ажил идэвхтэй хайгч 605 иргэн бүртгэснээс 271 эмэгтэй.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 34 байна.<br>"ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-2025" хөдөлмөрийн өдөрлөгийг 2025 оны 04 дугаар сарын 10-ний өдөр аймгийн Засаг даргын тамгын газар, Архангай мэргэжлийн боловсролын сургууль, Булган мэргэжлийн боловсролын сургууль, Гурван тамир мэргэжлийн боловсролын сургуулиудтай хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 281 иргэн хамрагдаж, төр, хувийн хэвшлийн 125 ажлын байр нээлттэй танилцуулагдсан. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил-2025” үндэсний хэмжээний нээлтийн үйл ажиллагаа “Хамгийн сайн халамж — хөдөлмөр эрхлэлт” уриатай зохион байгуулж 205 оны 10 сард ХБИ-ийн ажил мэргэжлийн ур | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадварын уралдааныг 6 төрлөөр зохион байгуулж 53 иргэн хамрагдаж Улсын уралдаанд 9 иргэнийг оролцууллаа. | |
| 3.2.2.3 | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | 1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Ажилгүй иргэн, ажилгүйдэлт өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэдийн судалгааг аймгийн хэмжээнд 2025.02.20-ны өдрөөс 2025.03.14-ны хооронд 19 сумын 99 багаас нийт 8293 иргэдийн судалгааг авч нэгтгэсэн. Үүнээс эмэгтэй 4549, эрэгтэй 3744 байна. Ахмад настан 471, хөгжлийн бэрхшээлтэй хүн 436, оюутан 275, их дээд сургууль болон МБСБайгууллагыг төгсөгч 252, ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч 951, байнгын асаргаатай гэр бүлийн гишүүнээ асардаг иргэн 172, бага насны хүүхдээ асарч байгаа иргэн 654, гадаадад амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэн 12, малчин /малгүй болон цөөн малтай өрхийн гишүүн/ 4211, хорихоос суллагдсан иргэн 9, бусад 850 хамрагдсан. Дээрх иргэдээс 1608 буюу 19% нь мэргэжилтэй, 6685 буюу 81% нь ямар нэгэн мэргэжил эзэмшээгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдах хүсэлтэй 148 иргэний хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг хийж, 63 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулан ажиллалаа. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогч байгууллагаас 1070 ажлын байрны захиалга авч 400 иргэнийг ажилд зуучилж 5,811.2 мянган төгрөгийг зарцуулсан. | Хэрэгжсэн |
| 3.2.2.4 | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн төлөв байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зохицуулалтыг хийж ажиллах | | Судалгаа, мэдээллийн тоо | Аймгийн/сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг эдийн засгийн салбар болон ажил мэргэжлийн байдалтай уялдуулан нарийвчлан судаллаа. Судалгаанд аймгийн 50 гаруй аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг хамруулж, 148 ажил хайгч, ажилгүй иргэдээс анкет болон ярилцлага авсан.<br>Хөдөө аж ахуйн салбарт малын эмч, агрономич мэргэжлийн хүний эрэлт 85 байхад нийлүүлэлт 42 болж 43 хүний дутагдалтай байгааг тогтоосон. Эрүүл мэндийн салбарт | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сан үүссэн байна. | сувилагч, бага эмчийн эрэлт 60, нийлүүлэлт 30 хүн байж 30 хүний зөрүү гарсан. Барилгын салбарт мэргэшсэн ажилтны дутагдал 35, харин худалдаа үйлчилгээний салбарт ажиллах хүчний нийлүүлэлт эрэлтээс 20-оор илүү гарсан байна.<br>Ажилгүй иргэдийн 38 хувь нь дээд боловсролтой, 42 хувь нь мэргэжлийн боловсролгүй, 20 хувь нь техник мэргэжлийн боловсролтой хүмүүс байгаа бөгөөд 65 хувь нь 20-35 насны залуус байна. Судалгааны үндсэн дүнгээр Архангай аймагт салбар хооронд хүний нөөцийн тэнцвэргүй байдал, мэргэжлийн сургалт, давтан сургалтын хомсдол, ялангуяа хөдөө орон нутгийн багш, эмч, инженерийн орон тооны дутагдал тулгамдсан асуудал болж байна. | |
| 3.2.2.5 | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | | 1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>2.Холбогдох арга хэмжээний тоо<br>3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 14 иргэнийг түр ажлын байраар, 4 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, 48 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан. Үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны 128 иргэнийг и-жоб программд ажил идэвхитэй хайгч иргэнээр бүртгэн зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн насны хүн ам дахь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсний дунд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 69.6 хувьтай байна. | Хэрэгжсэн |
| 3.2.2.6 | Орон нутагт албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэний мэдээллийг гаргах | | | | 2025 оны 1 улиралд албан бусаар хөдөлмөр эрхэлж буй 160 иргэдийн судалгааг авсан.<br>Ажилгүй буюу ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй 198 иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээг хийн тохирох үйлчилгээ, арга хэмжээнд зуучилсан. | Хэрэгжсэн |
| 3.2.2.7 | Зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогод, нийцэхгүй үйл ажиллагаа | | | | Хөдөлмөрийн тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээний ажлууд тусгагдсаны дагуу 22 аж ахуйн нэгж байгууллагын 83 албан хаагчдад 4 удаагийн сургалт зохион байгуулж мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.8 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | 1.Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2.Холбогдох арга хэмжээний тоо | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. | Архангай аймгийн ХХҮГ-т ирүүлсэн "Ирмүүн төгс" ХХК хүсэлтийн дагуу Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний нэгдсэн платформыг нэвтрүүлж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор орон нутагт "ЖОБ ЦЕНТЕР" төвийн үйл ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нээж үйл ажиллагааг эхлүүлээд байна. | Хэрэгжсэн |
| 3.2.2.9 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | 1.Хяналт шалгалтын тоо<br>2.Судалгаа, мэдээллийн тоо<br>3.Холбогдох арга хэмжээний тоо | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Эрдэнэбулган суманд 2024, 2025 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 66 иргэн байна. Тус иргэдийн ажлын байртай танилцах, мөн үйл ажиллагаа нь зориулалтын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавихаар 2025 оны 09 сард ХХҮГазрын дарга, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Хяналт шалгалтаар төсөл хэрэгжүүлэгч 39 иргэний үйл ажиллагаатай танилцан, эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөх, түрээс, борлуулалтын дэмжлэгийн талаарх зөвлөгөө мэдээлэл өгч, ХХҮГазрын фэйсбүүк хуудсаар тухайн иргэдийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан байдал тогтоогдоогүй | Хэрэгжсэн |
| 3.2.2.10 | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | 1.Холбогдох арга хэмжээний тоо<br>2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна. | "Старт-Ап" залуучуудад гарааны бизнесээ эхлүүлэх бизнес санааг баяжуулах өрсөлдүүлэх багаар ажиллаж ирээдүйтэй санааг менторын туслалцаатай хөгжүүлэх, гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн үйл ажиллагааг "Нэгдмэл үйлс Нэг сэтгэл ТББ-тай хамтран зохион байгуулж 5,600.0 мянган төгрөгийг зарцуулсан.<br>Шилдэг "Старт-Ап" залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд NOMADS-шим багийн ахлагч М.Нарандулам 1 дүгээр байр, ARVR- интерьер дизайны зөвлөх үйлчилгээ багийн ахлагч Ч.Ган-Эрдэнэ 2 дугаар байрт шалгарсан.<br>Шилдэг "Старт-Ап" залуу, залуучуудын багт хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 30,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон. | |
| 3.2.2.11 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах; | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 8 сумын 29 иргэнд борлуулалтын дэмжлэгт хамруулж 1,373.7 мянган төгрөгийг зарцуулсан.<br>ХЭДСангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэнд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5.460.0 мянган төгрөг, ХБИ-д олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 2 иргэнд 1,666.5 мянган төгрөгийн түрээсийн дэмжлэг, ХБИ-ний борлуулалтын цэгийн дэмжлэгээр 1,000.0 мянган төгрөг зарцуулсан. | Хэрэгжсэн |
| 3.2.2.12 | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | | Холбогдох арга хэмжээний тоо | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | 2025 онд хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг 2025 оны 02 дугаар сарын 21-ны А/79 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хуралдсан.<br>Тус хуралдаанаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай ХХҮЕГазрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 тоот тушаалаар батлагдсан төсвийн хуваарийг танилцуулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн даргаар төсөл, хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр 19 сумдад төсвийг хуваарьлан, баталж хэрэгжүүллээ. | Хэрэгжсэн |
| 3.2.2.13 | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ<br>2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй 6 аж ахуйн нэгж, байгууллагаас зохих төлбөрийг ХЭДС-д 40,788.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах. | | | хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй 25 ба түүнээс дээш ажилтантай 108 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 87 байгууллагад 194 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулж байна.<br><br>2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/618 тоот Архангай аймгийн Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан 25 буюу түүнээс дээш ажилтантай хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж буй 45 төрийн болон аж ахуй нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудад бодит нөхцөл байдлын үнэлгээ хийж, ажил эрхлэлтийн түвшин, ажлын байранд тулгардаг асуудал, хүндрэл бэрхшээл, ажлын байрны тохируулга хийсэн эсэхтэй танилцан ажил олгогч болон ажилтны судалгааг авч байгууллагуудад мэдээлэл хүргэн ажиллалаа. | |
| 3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 25 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 3.2.3.1 | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгө өр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх. | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | Засаг даргын нөөц сангаас 4,500.0 мянган төгрөгийг ХАБЭА салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулсан.<br>"ХАБЭА сарын аян 2025" арга хэмжээг өрнүүлж, 41 ААН, байгууллагын 310 ажилтан албан хаагчид болон иргэдэд Хөдөлмөрийн тухай хууль, үйлдвэрлэлийн осол гэмтлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.<br><br>2025 онд үйлдвэрлэлийн осол 2 удаа гарсан үйлдвэрлэлийн ослын актыг зохих хугацаанд нь хянан баталгаажуулж үйлдвэрлэлийн осол хурц хордлогын бүртгэл мэдээллийн www.om.inspection.gov.mn цахим системд бүртгээд байна. 2025 онд аймгийн хэмжээнд хурц хордлого гараагүй болно. | Хэрэгжсэн |
| 3.2.3.2 | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг | Орон нутгийн төсвийн | 1.Төлөвлөсөн төсөв<br>2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | хөрөнгө өр | | | өдрийн А/01 тоот аймгийн засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулсан.<br><br>ХАБЭА-н зөвлөлөөс 21 аж ахуйн нэгж байгууллагын дарга захирал, ажил олгогч болон 19 сумдын засаг дарга нарт үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх, тохирох хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийлгэх зөвлөмжийг албан бичгээр хүргүүлэн, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлье" зөвлөмж, 120 ширхэг гарын авлагыг зорилтот бүлгийн иргэд болох хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдад түгээж, олон нийтийн газар, байгууллагын мэдээллийн самбар байршуулах чиглэлийг өгч ажилласан. Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлтэй хамтран Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургууль, аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Дотоодын цэргийн 831-р тусгай салбар, Архангайн Ус Суваг ОНӨААТҮГазрын нийт 25 байгууллагын ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан 335 ажилчдад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан зарим асуудлууд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан ажил олгогч, ажилтны эрх үүргийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа." | |
| 3.2.3.3 | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг | Орон нутгийн төсвийн хөрөнгө өр | 1.Төлөвлөсөн төсөв<br>2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо | Тухай бүр арга хэмжээ авсан байх | 2025 онд үйлдвэрлэлийн осол 2 удаа гарсан үйлдвэрлэлийн ослын актыг зохих хугацаанд нь хянан баталгаажуулж үйлдвэрлэлийн осол хурц хордлогын бүртгэл мэдээллийн www.om.inspection.gov.mn цахим системд | Хэрэгжсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах. | | | | бүртгээд байна. 2025 онд аймгийн хэмжээнд хурц хордлого гараагүй болно. | |
| 3.2.4 Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | |
